



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/519

Булган сум

Сумын Засаг дарга, тосгоны  
Захирагч нарын 2023 оны эхний хагас жилийн  
гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга нар, тосгоны Захирагчийн 2023 онд хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний урамшууллыг батлагдсан төсөвтөө багтаан гаргахыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэсэн байдалд дүн шинжилгээ хийж, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг заалт нэг бүрээр нь хяналтад авч биелэлтийг бүтэн жилээр тооцож тайлагнахыг сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323030532

Аймгийн Засаг даргын 2023 оны  
06 дугаар сарын 29-ний өдрийн  
А/5.19 тоот захирамжийн хавсралт

**Аймгийн Засаг даргатай сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарын  
хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ**

| №  | Сум, тосгоны нэрс | Үнэлгээ хувиар | Үнэлгээний урамшуулал              |
|----|-------------------|----------------|------------------------------------|
| 1  | Баян-Агт сум      | 80.6           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 2  | Баяннуур сум      | 80.2           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 3  | Бугат сум         | 80.0           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 4  | Булган сум        | 86.1           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 5  | Бүрэгхангай сум   | 84.7           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 6  | Гурванбулаг сум   | 81.8           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 7  | Дашинчилэн сум    | 81.6           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 8  | Могод сум         | 81.4           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 9  | Орхон сум         | 81.1           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 10 | Рашаант сум       | 80.0           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 11 | Сайхан сум        | 80.8           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 12 | Сэлэнгэ сум       | 86.1           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 13 | Тэшиг сум         | 80.0           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 14 | Хангал сум        | 80.3           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 15 | Хишиг-Өндөр сум   | 81.0           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 16 | Хутаг-Өндөр сум   | 84.8           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |
| 17 | Хялганат тосгон   | 80.5           | 30 хүртэлх хувийн урамшуулал олгох |

-----oOo-----